



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мон-Атом ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/41/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 51- 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК Захирал Ж.Бямбажав Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Компани ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компани ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	11
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл



МОН-АТОМ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ДАЛАЙЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV баир, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 061684

ганаа _____ -ны № _____ -г

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон-Атом ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ес зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангуудад хийсэн аудитаар 988.1 сая төгрөгийн зерчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээр санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Урт хугацаат зээлийн 946.3 сая төгрөгийг Чех улсын "Ураниум индастри" ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- "Уран-2" нэртэй богино хэмжээний киног орлогод бүрэн хүлээж аваагүй 40.0 сая төгрөгийн гэрээ дүгнэсэн акт үйлдэн, зар сурталчилгааны зардалд бүртгэсэн;
- Чин сүрвэй ХХК-тай "Газрын зураг хийх" 38.9 сая төгрөгийн гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6, 15.2.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 23 дугаар зүйлийн 23.2, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолын журмын "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 20.0 сая төгрөг" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мон-Атом ХХК тайлант онд Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын хүрээнд цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгийг өсгөн нэмэгдүүлэх, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч улмаар тэргүүлэгч орны нэг болох, нөлөө бүхий улсуудын стратегийн сонирхлыг бий болгох, Монгол Улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг ханган ажиллажээ.

Мон-Атом ХХК нь Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон Орд ашиглах гэрээнүүдийг 2025 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна. Ингэснээр эдийн засгийн ач холбогдолтой төслийг эхлүүлэн компани жил бүр ноогдол ашиг хүртэх боломж бүрдэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол-Францын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн "Зөөвч Овоо" төслийн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу 2028 оноос үндсэн үйлдвэрлэл эхэлснээр Мон-Атом ХХК нь 2030 оноос давуу эрхийн 10.0 хувийн ногдол ашиг авахаар байна.

Бусад асуудал

Мон-Атом ХХК нь Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу Гурвансайхан ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааг үнэ төлбөргүй шууд эзэмших нөхцөл бүрдэж дараагийн төслийн үйл ажиллагааг эхлүүлэхээр болсон байна.

Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 57 зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	45,801,610.58	29,998,209.05
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	120,078,587.92	140,122,060.62
1.1.4	Бусад авлага	439,789.06	136,109.98
1.1.6	Бараа материал	14,488,032.33	19,497,095.06
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	81,505,530.74	5,000,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	262,313,550.63	194,753,474.71
1.2.1	Үндсэн хөрөнгө	54,129,050.21	88,519,477.51
1.2.2	Биет бус хөрөнгө	10,606,060.60	6,060,606.06
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,716,678,770.00	1,716,678,770.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,781,413,880.81	1,811,258,853.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,043,727,431.44	2,006,012,328.28
2.1.1.1	Дансны өглөг	2,565,612.67	-
2.1.1.3	Татварын өр	17,607,380.57	20,177,597.06
2.1.1.4	НДШ - ийн өглөг	234,818.64	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	20,407,811.88	20,177,597.06
2.1.2.1	Урт хугацаат зээл	12,572,050,729.99	14,690,946,964.81
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,572,050,729.99	14,690,946,964.81
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,592,458,541.87	14,711,124,561.87
2.3.1	Өмч:	1,721,206,770.00	1,721,206,770.00
2.3.1.1	- төрийн	1,721,206,770.00	1,721,206,770.00
2.3.7	Хуримтлагдсан ашиг	(12,269,937,880.43)	(14,426,319,003.59)
2.3.9	Эздийн өмчийн дүн	(10,548,731,110.43)	(12,705,112,233.59)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,043,727,431.44	2,006,012,328.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	206,834,492.40
3	Нийт ашиг (алдагдал)	-	206,834,492.40
5	Хүүгийн орлого	700,508.64	744,658.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,007,730,104.02	1,423,182,628.11
11	Санхүүгийн зардал	764,226,235.73	901,994,394.60
12	Бусад зардал	1,780,955.00	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(369,393.25)	(41,274,376.53)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,773,406,179.36)	(2,158,872,248.48)
19	Орлогын татварын зардал	70,050.86	74,487.35
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(1,773,476,230.22)	(2,158,946,735.83)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,773,476,230.22)	(2,158,946,735.83)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(1,773,476,230.22)	(2,158,946,735.83)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,721,206,770.00	(10,548,922,292.03)	(8,827,715,522.03)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	52,460,641.82	52,460,641.82
Залруулсан үлдэгдэл	1,721,206,770.00	(10,496,461,650.21)	(8,775,254,880.21)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(1,773,476,230.22)	(1,773,476,230.22)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,721,206,770.00	(12,269,937,880.43)	(10,548,731,110.43)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	2,565,612.67	2,565,612.67
Залруулсан үлдэгдэл	1,721,206,770.00	(12,267,372,267.76)	(10,546,165,497.76)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(2,158,946,735.83)	(2,158,946,735.83)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,721,206,770.00	(14,426,319,003.59)	(12,705,112,233.59)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	1,693.83	206,842,027.79
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	206,834,492.40
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,693.83	7,535.39
1.2	Мөнгөн зарлагын дүн	942,375,904.82	1,238,702,085.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	454,384,770.98	555,090,191.01
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	136,239,059.53	165,662,065.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,790,430.00	13,923,789.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	500,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	70,050.86	74,487.35
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	48,640,717.97	64,773,414.83
1.2.9	Бусад мөнгөн зарлага	291,250,875.48	438,678,137.60
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(942,374,210.99)	(1,031,860,057.21)
2.1	Мөнгөн орлогын дүн	14,895,358.64	744,658.36
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	14,194,850.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	700,508.64	744,658.36

Мон-Атом ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2	Мөнгөн зарлагын дүн	166,175,033.00	160,637,811.92
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	22,184,000.00	37,332,900.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	143,991,033.00	123,304,911.92
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(151,279,674.36)	(159,893,153.56)
3.1	Мөнгөн орлогын дүн	1,117,363,363.00	1,176,052,326.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,117,363,363.00	1,176,052,326.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	6,874,681.79	102,516.76
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,110,488,681.21	1,175,949,809.24
4.	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	16,834,795.86	(15,803,401.53)
5.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,966,814.72	45,801,610.58
6.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,801,610.58	29,998,209.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Х/н	2024 он	2025 он		Харьцуулалт			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			-	-	-	-	-	-	-
2	Нийт орлого	м.төг	700.5	-	207,579.2	206,878.7	29,633.0	207,579.2	-
3	Нийт зардал	м.төг	1,772,705.7	2,517,064.0	2,366,451.4	593,745.7	133.5	(150,612.6)	94.0
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	1,007,730.1	1,723,366.0	1,423,182.6	415,452.5	141.2	(300,183.4)	82.6
4	Татварын өмнөх ашиг	м.төг	(1,772,005.2)	(2,517,064.0)	(2,158,872.2)	(386,867.0)	121.8	358,191.8	85.8
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(1,773,476.2)	(2,517,064.0)	(2,158,946.7)	(385,470.5)	121.7	358,117.3	85.8
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	191,160.6	231,819.4	231,819.4	40,658.8	121.3	-	100.0
	а/ Орлогын татварт	м.төг	70.1	74.5	74.5	4.5	106.4	-	100.0
	б/ НӨТ	м.төг	-	-	-	-	-	-	-
	в/ НДШ	м.төг	139,551.1	165,662.1	165,662.1	26,111.0	118.7	-	100.0
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	51,340.7	63,164.6	63,164.6	11,823.9	123.0	-	100.0
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-	-	-	-
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	198.8	356.6	356.6	157.8	179.4	-	100.0
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	-	2,561.7	2,561.7	2,561.7	-	-	100.0
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг				-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	12.0	12.0	12.0	-	100.0	-	100.0
9	Нийт цалингийн сан	м.төг	460,905.9	567,153.0	556,529.4	95,623.5	120.7	(10,623.6)	98.1
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,200.7	3,938.6	3,864.8	664.1	120.7	(73.8)	98.1
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	-	-	-	-	-	-	-
12	Хөрөнгө оруулалт	м.төг	51,600.0	39,390.0	36,783.9	(14,816.1)	71.3	(2,606.1)	93.4
13	Нийт авлага	м.төг	120,517.0	140,258.2	140,258.2	19,741.2	116.4	-	100.0
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	12,592,458.5	14,711,124.5	14,711,124.5	2,118,666.0	116.8	-	100.0
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	20,407.8	20,177.6	20,177.6	(230.2)	98.9	-	100.0
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	12,572,050.7	14,690,946.9	14,690,946.9	2,118,896.2	116.9	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх” чиг үүрэгтэй 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан байна.

Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор Мон-Атом ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлж, тус компанийн охин компани болсон. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3-т заасны дагуу Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдал Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг улс орнуудтай цөмийн эрчим хүч, судалгаа шинжилгээ болон ураны салбарт хамтран ажиллах гэрээ, харилцан ойлголцлын санамж бичгүүд байгуулан ажиллаж байна.

Мон-Атом ХХК нь “Цацраг идэвхт ашигт малтмалын салбарт олон улсын жишигт нийцсэн сайн менежмент бүхий үнэ цэнэ, үр өгөөжийг нэмэгдүүлсэн үндэсний бие даасан компани болох” эрхэм зорилгын хүрээнд “Компанийн сайн засаглалыг бэхжүүлсэн, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчин бүхий тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замаар хүн ам, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино” гэж тодорхойлон үйл ажиллагаагаа явуулж байна.

Дэвшүүлсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Цацраг идэвхт ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын тоон мэдээллийн сан үүсгэх, уранжилтын хувьд хэтийн төлөвтэй талбайг урьдчилсан байдлаар ялгах, судалгаа хийх;
- Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна орлого олох боломжийн судалгаа хийх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, шар нунтаг, цөмийн технологийн талаар олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэр, төрийн захиргааны төв байгууллага болон Эрдэнэс Монгол ХХК-ийн өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангах;
- Хууль тогтоомж эрх зүйн баримт бичигт нийцүүлэн компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтыг сайжруулах, боловсон хүчнийг чадавхжуулах.

3.2 Компани ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Мон-Атом ХХК нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжууд болон Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын нэгдэн орсон конвенц, Олон Улсын гэрээ хэлэлцээр зэрэгт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол-Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн “Зөөвч Овоо” төслийн хөрөнгө оруулалтын гэрээ хийгдсэн бөгөөд тус төслийн техник эдийн засгийн үндэслэлд тусгаснаар 2028 оноос үндсэн үйлдвэрлэл эхэлж 2030 оноос давуу эрхийн 10%-ийн ногдол ашиг авахаар байна. Иймд дээрх хугацаа хүртэл толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-аас зээлийн санхүүжилт авч ажиллахаар төлөвлөсөн байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын хууль “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай”;
- Монгол Улсын хууль “Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай”;

- Сангийн сайдын А/103, 104, 105, 106 дугаар “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах” тухай тушаалууд

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Компани нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, толгой компани “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хяналтын үүрэг хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мон-Атом ХХК-ийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 76 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Мон-Атом ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	45,801.6	29,998.2	(15,803.4)
Авлага	120,518.4	140,258.2	19,739.8
Урьдчилгаа	81,505.5	5,000.0	(76,505.5)
Бараа материал	14,488.0	19,497.1	5,009.1
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,716,678.8	1,716,678.8	-
Үндсэн хөрөнгө	64,735.1	94,580.1	29,845.0
Нийт хөрөнгө	2,043,727.4	2,006,012.3	(37,715.1)
Өр төлбөр	12,592,458.5	14,711,124.6	2,118,666.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	(10,548,731.1)	(12,705,112.2)	(2,156,381.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,043,727.4	2,006,012.3	(37,715.1)

Дээрх хүснэгтээс үзэхэд мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж гарсан зардал, өр төлбөр, хуримтлагдсан ашиг, алдагдлын данснууд материаллаг дүнтэй өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 29.9 сая төгрөг болж, оны эхнээс 15.8 сая төгрөгөөр буурсан нь гэрээт ажлын ажил үйлчилгээний урьдчилгааг барагдуулсан;
- Авлагын үлдэгдэл оны эцэст 140.2 сая төгрөг болж, 116.4 хувиар нэмэгдсэн нь Нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 21.0 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан;
Авлага дансны үлдэгдэлд Нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 140.1 сая төгрөгийн, ажилчдаас авах авлага 0.1 сая төгрөг байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 19.4 сая төгрөг болж, өмнөх оноос 5.0 сая төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 19.9 сая төгрөгөөр бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 14.9 сая төгрөгөөр бараа материал зарцуулсан;
- Урьдчилж гарсан зардал дансанд Уран-11 баримтат кино хийлгэхээр төлсөн 60.0 сая төгрөгийн төлбөр, аудитын үйлчилгээнд төлсөн 5.5 сая төгрөг, программ хангамж, бусад зардалд төлсөн 9.1 сая төгрөг тус тус зарцуулан нийт 76.5 сая төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 94.5 сая төгрөг болж, өмнөх оноос 29.8 сая төгрөгөөр өссөн нь “Эрдэнэс Монгол” ХХК-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авсан үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой;
- Богино хугацаат өр төлбөр дансанд урт хугацаат зээлийн тайлант үед ногдох хүү, зээлийн өглөг 2,118.8 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөөлсөн;
- Урт хугацаат өр төлбөр болон урт хугацаат зээл дансны үлдэгдэлд “Эрдэнэс Монгол” ХХК-аас авсан зээл болон зээлийн хүүгийн дүн 14,690.9 сая төгрөг, татварын өглөг 20.1 сая төгрөгийн өр төлбөр тус тус байна.
- Засгийн газрын хувь оролцоо 2.1 сая төгрөгөөр алдагдал өссөн нь тайлан хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Биет бус хөрөнгийн дансанд 13.6 сая төгрөгийн веб сайт бүртгэлтэй бөгөөд baaz.mn онлайн санхүүгийн программ ашиглаж жилд 0.7 сая төгрөгийн ашиглалтын хураамж төлж байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мон-Атом ХХК үйл ажиллагааны болон зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 88-р тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг төлөвлөөгүй, нийт зардлыг 2,517.0 сая төгрөгөөр, төлөвлөсөн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 39.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Тус компани нь одоогоор охин болон хараат компанид үндсэн үйлдвэрлэл эхэлж борлуулалт хийгээгүй тул эзэмшиж буй хувьцаанаас ногдол ашиг хүртээгүй “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр банкны хүүгийн болон цацраг идэвхт газрын илэрцийг илрүүлсний үйлчилгээний төлбөр нийт 207.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,366.4 сая төгрөгийн зардал гарган, 2,158.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-аас 1,706.2 сая төгрөгийн зээлийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,176.0 сая төгрөгийг авсан байна.

Гүйцэтгэлээр ажил үйлчилгээний орлого 206.8 сая төгрөг, банкны хүүгийн орлого 0.7 сая төгрөг буюу нийт 207.5 сая төгрөгөөр орлого давсан нь төлөвлөгөө батлагдаагүйгээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд үйл ажиллагааны зардал 2,366.4 сая төгрөг буюу 94.0 хувь, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 36.7 сая төгрөг буюу 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үйл ажиллагааны зардлын 62.0 хувийг цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, 12.0 хувийг зар сурталчилгааны зардал, 9.0 хувийг албан томилолтын зардал, 6.0 хувийг судалгаа болон хөгжүүлэлтийн зардал, 11.0 хувийг бусад бараа материал, бичиг хэрэг, шуудан холбоо гэх зэрэг зардал эзэлж байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,366.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 150.6 сая төгрөг буюу 6.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин 8.7 сая төгрөг, томилолт 63.1 сая төгрөг, зар сурталчилгаа 48.3 сая төгрөг, судалгаа болон хөгжүүлэлтийн 30.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 39.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1.Төвийн орон тооны цомхотголын талаар:

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 118 дугаар тогтоолоор Мон-Атом ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан байна. Тус тушаалын хоёрдугаар хавсралтаар орон тоог 14 ажилтантай байхаар баталсны дагуу тус компанийн захирлын 2025 оны 1 дүгээр сарын 2-ний өдрийн “Үндсэн цалингийн хэмжээ тогтоох тухай А/1 дүгээр тушаалаар 14 орон тоо баталж гүйцэтгэлээр 12 орон тоотой ажилласан байна.

2.Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн 88 дугаар тогтоолоор ажлын нэг өдрийн хоолны зардлыг 6.0 мянган төгрөг, унааны зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож тайлант хугацаанд 26,052.0 мянган төгрөгийг унаа, хоолны зардалд зарцуулсан байна.

3.Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн:

Тус компани нь гадаад томилолтод 186.3 сая төгрөг батлагдсанаас 115.8 сая төгрөг зарцуулж 70.5 сая төгрөг дутуу зарцуулсан байна. Тухайлбал: Казакстан Улсын Алмата хотод “Казатомпром” компанитай хамтран ажиллах уулзалтад 38.7 сая төгрөг, БНЧУ-ын “Ураниум Индастри” ХК-тай гэрээ байгуулах 9.9 сая төгрөг, Монгол-Францын Засгийн газрын хоорондын комиссын хуралдаанд оролцох 6.2 сая төгрөг, Улаанбаатар-Бээжин-Москва хотод болсон “Атомэкспо 2025” олон улсын хуралд оролцох 66.9 сая төгрөгийг тус тус зарцуулан олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалтад оролцон үр дүнг тайлагнаж ажилласан байна.

4.Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн

“Индивидуал рестаурант” ХХК-д Франц улсын төлөөлөгчидтэй хийсэн семинар уулзалт зөвлөгөөн болон Монголын эко хор судлаачдын нийгэмлэгээс химийн бодисын талаарх сургалт, ажлын байрны дотоод сургалт зэрэгт сургалтын зардал, хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээнд 3.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Тэгүс би”, “Ханлиг Лежен”, “Номандик трешүрс”, “Ай Эс Ди Руби”, “Чиг медиа групп”, “Юу Эй Жи Би Солюшн”, “ГЭО Трейд”, иргэн А.Баатархуяг, Монголын кино продюсерын холбоо, Креатив медиа лаб зэрэг компаниудтай гэрээ хэлцлийн дагуу Уран-1, 2 баримтат кино, Уран болон цацраг идэвхт ашигт малтмалын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөх, “Зөөвч Овоо” төслийн талаар баримтат видео материал бэлдэх, газар дор уусган боловсруулах технологийн талаар танилцуулаг цахим орчинд түгээх, хөрөнгө оруулалтын гэрээг олон нийтэд сурталчлах, иргэдэд мэдлэг, мэдээлэл олгоход зар сурталчилгааны зардлаас нийт 179.8 сая төгрөг зарцуулсан байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 39.3 сая төгрөгийн 6 нэр төрлийн бараа худалдан авахаар төлөвлөж, баталсан байна.

Гүйцэтгэлээр ухаалаг дэлгэц, оффис сандал, ус цэвэршүүлэгч, компьютер нийт 36.7 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мон-Атом ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Мон-Атом ХХК-ийн түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах урьдчилж төлсөн зардал, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дундманхайдай аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Тэмүүжин, аудитор Н.Гантөмөр нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтыг менежер Б.Цэвэлмаа, анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Я.Марал-Эрдэнэ, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Мон-Атом ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/30 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,774.1 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, 17.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тус компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,325.1 сая төгрөг буюу 31.1 хувиар өссөн тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 1.0 хувиар тооцож, 23.2 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллахаар байгууллагын батлагдсан бүтэц орон тоог шинэчлэн, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,366.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 150.6 сая төгрөг буюу 6.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Тухайлбал: Цалин 8.7 сая төгрөг, томилолт 63.1 сая төгрөг, зар сурталчилгаа 48.3 сая төгрөг, судалгаа болон хөгжүүлэлтийн зардлыг 30.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 140.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" болон "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 45.1 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, 56.1 сая төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт:

Чин сүрвэй ХХК -тай "Газрын зураг хийх" 38.9 сая төгрөгийн гэрээ байгуулан худалдан авах өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 1 сарын 3-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолын журмын " Шууд худалдан авах өртгийн дээд хязгаар бараа 20.0 сая төгрөг" гэснийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил үйлчилгээг шууд худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт нь холбогдох хууль, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус компанийн 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулан мөнгөн хөрөнгө, бараа материал, борлуулалтын орлого, цалингийн данстад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 1,969.7 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлж, асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажууллаа. Жилийн эцсийн аудитаар залруулга хийсэн эсэхийг дахин нягталж, аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1351 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт биелэлтийн тайлан, нотлох баримтыг хамт ирүүлсэн байна.

Аудитын явцад биелэлтийг хянаж үзэхэд 62.5 сая төгрөгийн 3 албан шаардлага 100 хувь биелэлттэй, 1 зөвлөмж 60 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	3	62,565.6	3	62,565.6	100.0
2	Зөвлөмж	1	-		-	60.0
Нийт дүн		4	62,565.6	3	62,565.6	75.0

Өмнөх аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлэх, холбогдох стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын дансны хангамжийн материал, багаж хэрэгслийн үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,969.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг залруулсан.

Залруулсан алдаа:

- Мөнгөн хөрөнгийн данснаас заалны үйлчилгээ, машин засвар, хүлээн авалтын хүнс, хангамжийн материалын төлбөрийг төлөхдөө 411.1 сая төгрөгийг тооцоо үүсгээгүй зардлаар бүртгэсэн, томилолтын 147.8 сая төгрөгийг урьдчилж олгохдоо "Дараа тайлангийн тооцооны данс"-аар бүртгэхгүйгээр мөнгөн хөрөнгийн данснаас "Томилолтын зардал"-ын дансанд шууд бүртгэсэн;
- Төрийн банкны харилцах дансны 1,242.4 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг "Манай байгууллага" гэсэн нэрээр бүртгэж, харилцагч байгууллагын нэрийг үнэн зөв бүртгээгүй, тооцоог үүсгээгүй;
- Хангамжийн бараа материалыг орлого авахдаа нэр төрөл тус бүрээр нь бүртгээгүй, падааны үнийн дүнгээр авч зарлага гаргасан. Тухайлбал: Авзага баян бэрх ХХК-аас 1.2 сая төгрөгийн Бичиг хэргийн материал, Скай хайпермаркет ХХК-аас 3 удаагийн худалдан авалтын нийт 1.5 сая төгрөгийн ариун цэврийн материалыг тус тус шууд зардалд бүртгэсэн;
- Цалингийн зардлыг давхардуулан бүртгэснээс 56.7 сая төгрөгөөр цалингийн өглөг дансанд үлдэгдэлтэй;
- Борлуулалтын орлого 103.2 сая төгрөгийг татварын тайланд И-баримт шивж тайлагнаагүй;
- Худалдан авсан хангамжийн материалыг орлогоор бүртгэж тайлан гаргаагүй, 5.5 сая төгрөгийг шууд зардалд бүртгэсэн;

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдээдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 988.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 1.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 946.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 40.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 988.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1:

Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж "Таван богд нура" ХХК-тай 8.8 сая төгрөгийн гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн бөгөөд 2 ажилтны 0.6 сая төгрөгийг "Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр"-тэй давхардуулан илүү шилжүүлж суутган тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 -д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөрт илүү шилжүүлсэн 0.6 сая төгрөгийг төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Илрүүлэлт 2:

Компанийн 5 ажилтанд ээлжийн амралтын цалинг 1.1 сая төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т “ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно”, 110 дугаар зүйлийн 110.2-т “ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцээгүй;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Компанийн 5 ажилтанд ээлжийн амралтын цалинг 1.1 сая төгрөгөөр илүү тооцож олгосоныг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1:

Урт хугацаат зээлийн 946.3 сая төгрөгийг Чех Улсын “Ураниум индастри” ХХК-тай цахимаар хүсэлтийг илгээсэн боловч, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдгийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Урт хугацаат зээлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 261 ширхэг 155.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгаагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр

Журам шинэчлэн батлах тухай тогтоолын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урьдчилж төлсөн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Уран-2 "нэртэй богино хэмжээний киног орлогод бүрэн хүлээж аваагүй 40.0 сая төгрөгийн гэрээ дүгнэсэн акт үйлдэн, зар сурталчилгааны зардалд бүртгэсэн байна

Энэ нь Иргэний хуулийн 348 дугаар зүйл 348.1 -т "Хуульд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэх гэрээний хугацааг талууд тохиролцон тодорхойлох бөгөөд ажлын онцлогийг харгалзан завсрын буюу тусгай хугацаа тогтоож болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 -д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бие бус хөрөнгийг стандарт журам, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруул-аагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн хөрөнгийн данснаас заалны үйлчилгээ, машин засвар, хүлээн авалтын хүнс, хангамжийн материалын төлбөрийг төлөхдөө 411,109.2 мянган төгрөгийг тооцоо үүсгээгүй зардлаар бүртгэсэн, томилолтын 147,833.8 мянган төгрөгийг урьдчилж олгохдоо "Дараа тайлангийн тооцооны данс"-аар бүртгэхгүйгээр мөнгөн хөрөнгийн данснаас "Томилолтын зардал"-ын дансанд шууд бүртгэсэн.	1	668,943.0	-	-	1	668,943.0	1	668,943.0	-	-	-	-
2	Төрийн банкны харилцах дансны 1,242,472.5 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг "Манай байгууллага" гэсэн нэрээр бүртгэж, харилцагч байгууллагын нэрийг үнэн зөв бүртгээгүй, тооцоог үүсгээгүй байна.	1	1,242,472.5	-	-	1	1,242,472.5	1	1,242,472.5	-	-	-	-
3	Хангамжийн бараа материалыг орлого авахдаа нэр төрөл тус бүрээр нь бүртгээгүй, падааны үнийн дүнгээр авч зарлага гаргасан. Тухайлбал: Авзага баян бэрх ХХК-аас 1,293.6 мянган төгрөгийн Бичиг хэргийн материал, Скай хайпермаркет ХХК-аас 3 удаагийн худалдан авалтын нийт 1,503.5 мянган төгрөгийн ариун цэврийн материалыг тус тус шууд зардалд бүртгэсэн байна.	1	2,797.1	-	-	1	2,797.1	1	2,797.1	-	-	-	-
4	Цалингийн зардлыг давхардуулан бүртгэснээс цалингийн өглөг дансанд үлдэгдэлтэй байна.	1	56,731.3	-	-	1	56,731.3	1	56,731.3	-	-	-	-
5	Борлуулалтын орлого 103,262.4 мянган төгрөгийг татварын тайланд Е баримт шивж тайлагнаагүй	1	103,262.4	-	-	1	103,262.4	1	103,262.4	-	-	-	-
6	Худалдан авсан хангамжийн материалыг орлого авч тайлан гаргаагүй, шууд зардалд бүртгэсэн	1	5,527.5	-	-	1	5,527.5	1	5,527.5	-	-	-	-
	Дүн	6	1,969,733.9	-	-	6	1,969,733.9	6	1,969,733.9	-	-	-	-

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	"Уран-2 "нэртэй богино хэмжээний киног орлогод бүрэн хүлээж аваагүй 40,000.0 мянган төгрөгийн гэрээ дүгнэсэн акт үйлдэн, зар сурталчилгааны зардалд бүртгэсэн;	1	40,000.0	-	-	-	-	1	40,000.0
2	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж Таван богд нура ХХК -тай 8,820.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн. Мөн 2 ажилтанд 617.9 мянган төгрөгийг 'Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр'-тэй давхардуулан шилжүүлж суутган тооцоо хийгээгүй байна.	1	617.9	1	617.9	-	-	-	-
3	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 261 ширхэг 155,625.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
4	Компанийн 5 ажилтанд ээлжийн амралтын цалинг илүү тооцож олгосон байна.	1	1,120.0	1	1,120.0				
5	Урт хугацаат зээлийн 946,387.7 мянган төгрөгийг Чех улсын Ураниум индастри ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	946,387.7	-	-	1	946,387.7	-	-
	Дүн	5	988,125.6	2	1,737.9	2	946,387.7	1	40,000.0

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" болон "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ"-г мөнгөн хөрөнгийн дансны журнал, харилцах дансны хуулгатай тулгахад 45,130.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, 56,100.0 мянган төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож	1	101,230.0	-	-	1	101,230.0	-	-
	Дүн	1	101,230.0	-	-	1	101,230.0	-	-
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2	Чин сүрвэй ХХК -тай "Газрын зураг хийх" 38,928.2 мянган төгрөгийн гэрээ байгуулан шууд худалдан авалт хийж журам зөрчсөн байна.	1	38,928.2	-	-	1	38,928.2	-	-
	Дүн	1	38,928.2	-	-	1	38,928.2	-	-
	Нийт дүн	2	140,158.2	-	-	2	140,158.2	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 148/A0150053

Улаанбаатар хот

САТ-2026/41/4А-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Мон-Атом" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хавсралтад дурдсан 5 ажилтанд ээлжийн амралтын цалинд 1,120,038.59 /нэг сая нэг зуун хорин мянга гучин найман төгрөг тавин есөн мөнгө/ төгрөгийг илүү тооцож олгосон байна.


Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажиллантай тохиролцон олгоно", 110 дугаар зүйлийн 110.2-т "ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалин нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ажилтны ээлжийн амралтын цалинд илүү тооцож олгосон 1,120,038.59 /Нэг сая нэг зуун хорин мянга гучин найман төгрөг тавин есөн мөнгө/ төгрөгийг Мон-Атом ХХК-ийн нягтлан бодогч Д.Батзаяагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Далайжаргал/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУЯДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 149/20150053

Улаанбаатар хот

С 10Г- 2026/41/НА- СТЭ-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мон-Атом ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан "Таван богд нура" ХХК-тай 8,820,000.00 /найман сая найман зуун хорин мянган/ төгрөгийн гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн боловч 2 ажилтанд 617,950.00 /зургаан зуун арван долоон мянга есөн зуун тавин/ төгрөгийг Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр-тэй давхардуулан илүү шилжүүлж, суутган тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" 20.2.5-д "дэнсны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх;" гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдээгдэлтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төрвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.7.5 "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийг төлбөрийг давхардуулан олгосон 617,950.00 /зургаан зуун арван долоон мянга есөн зуун тавин/ төгрөгийг "Мон-Атом" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Д.Батзаяа, албаны дарга Д.Сугарсүрэн нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкны дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт .
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Далайжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Д.Батзаяа/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 645/А0150053

Улаанбаатар хот

САН-2026/411/ХА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мон-Атом ХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урт хугацаат зээлийн 946,387,700.00 /есөн зуун дөчин зургаан сая гурван зуун наян долоон мянга долоон зуун/ төгрөгийг Чех улсын Ураниум индастри ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Урт хугацаат зээлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Далайжаргал/, санхүү бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Д.Батзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 онь 03 сарын 16 өдөр

Дугаар 646/20250053

Улаанбаатар хот

СЭГ-2026/41/НА-СТЭ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Мон-Атом" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 261 ширхэг 155,625,100.00 /нэг зуун тавин таван сая зургаан зуун хорин таван мянган нэг зуун/ төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр Журам шинэчлэн батлах тухай тогтоолын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна."


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10. "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол," гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Далайжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Батзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.Наранчимэг
Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.Бямбажав
Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 647/АД/50053

Улаанбаатар хот

С.АТ-2026/41/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мон-Атом ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 45,130,000.00 /Дечин таван сая нэг зуун гучин мянган/ төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, 56,100,000.00 /Тавин зургаан сая нэг зуун мянган/ төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Далайжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Батзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 648/АХК0053

Улаанбаатар хот

САГ-2026/41/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мон-Атом ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чин сүрвэй ХХК -тай "Газрын зураг хийх" 38.928.200.00 /Гучин найман сая есөн зуун хорин найман мянга хоёр зуун/ төгрөгийн гэрээ байгуулан худалдан авах өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 сугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Засгийн газрын 2024 оны 1 сарын 3-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолын журмын "Шууд худалдан авах өртгийн дээд хязгаар бараа 20.0 сая төгрөг" гэснийг зөрчиж, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй," гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил үйлчилгээг шууд худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Далайжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Батзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ